



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/118/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дорноговь аймаг
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhsetsege@audit.gov.mn

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 16/281

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Э.УНДАРМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	691.2	4,038.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,954.4	11,868.2
	Нийт хөрөнгийн дүн	11,645.6	15,907.1
	Нийт өр төлбөрийн дүн	183.8	1,018.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,461.8	14,889.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,645.6	15,907.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	11,590.2	18,538.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	9,565.1	15,003.6
	Үйл ажиллагааны үр дүн	2,025.2	3,534.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	-135.3	-107.5
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,889.8	3,427.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,461.8	11,632.7
	Тайлант оны үр дүн		3,427.3
	Эцсийн үлдэгдэл	11,461.8	14,889.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	8,974.7	12,772.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	8,886.6	12,665.8
	Үйл ажиллагааны ЦМГ	88.1	107.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-85.3	-102.3
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.00	0.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	2.8	4.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.3	3.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3.1	7.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		11,203.5
	Урсгал зардал		11,203.5
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		11,211.3
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		10,894.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		317.1

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн лавлагаа;
- Шатлалын хэвтүүлэн эмчлэх үйлчилгээ;
- Амбулаторийн үзлэг;
- Яаралтай түргэн тусламж;
- Оношилгоо шинжилгээний багц зэрэг тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.

Эрхэм зорилго: Эмнэлэг нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрд эрх тэгш хандах;
- Хувь хүний эрүүл мэндтэй холбоотой нууцыг хамгаалах, задруулахгүй байх;
- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
- Тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, шуурхай хүргэх, үзүүлэх;
- Ил тод, нээлттэй байж, иргэд, байгууллагад шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх.

Алсын хараа: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ЭМЯ-ны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 4/422 тоот албан бичгийн дагуу эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад 2021 оноос эхлэн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Мөн тайлант онд тус байгууллага нь харилцах дансны 7.8 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 142 мэдээллийг хугацаандаа оруулсан, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12.146.7 сая төгрөгийн 58 гүйлгээнээс 793.0 сая төгрөгийн 15 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 4,770.8 сая төгрөгийн 238 ажил гүйлгээнээс 94.6 сая төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна. Хөрөнгө зарцуулах 1,747.6 сая төгрөгийн 65 тушаал, шийдвэр гарсан байгаа ба үүнээс 45.3 сая төгрөгийн 6 тушаалыг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 10.4 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 10.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 1 албан шаардлага өгсөн.

Залруулсан алдаа:

1. Машин тоног төхөөрөмжийн элэгдлийг алдаатай тооцоолж 1.9 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцоолсныг залруулав.
2. Тохируулах бичилтийг буруу хийснээс үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 0.02 сая төгрөгөөр илүү тооцоолсныг залруулав.
3. Тайлант онд цалингийн тооцоололтой холбоотойгоор үүссэн авлагыг санхүүгийн тайланд 0.02 сая төгрөгөөр илүү тусгасныг залруулав.
4. Тайлант онд худалдан авсан 8.5 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байсныг залруулав.

Албан шаардлага:

1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 12.146.7 сая төгрөгийн 58 гүйлгээнээс 793.0 сая төгрөгийн 15 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын нийт 4,770.8 сая төгрөгийн 238 ажил гүйлгээнээс 94.6 сая төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна. Хөрөнгө зарцуулах 1,747.6 сая төгрөгийн 65 тушаал, шийдвэр гарсан ба системд 45.3 сая төгрөгийн 6 тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Мэдээллийг нөхөн байршуулах, хугацаандаа байршуулах, цаашид хугацаа хоцроох, мэдээллийг байршуулахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ									

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг	5	10.4	4	10.4	-	-	1	-	-	-
	НИЙТ	5	10.4	4	10.4	-	-	1	-	-	-